

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 оны 05 дугаар сарын мэдээлэл

2022.05.23.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит VIII хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр 2022.05.31 ний өдрийг товллоод байна. Үүнд:

1. Төсвийн тодотгол
2. 2022 оны Сумын Хөгжлийн төлөвлөгөө батлах
3. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамж
3. Ундны усны үнэ бууруулж тогтоох
4. Бусад асуудлыг тус тус хэлэлцэнэ.

-“ЗӨВ ХАНДЛАГА-ЭЕРЭГ НӨЛӨӨ” аяныг 2022.05.03-2022.06.16 ны хооронд зохион байгуулах 7 заалттай төлөвлөгөө гарган, аймгийн Засаг даргын 2022.05.03 ныА/233 дугаар захирамжийг албан бичгийн дагалдахтайгаар сумын төсвийн 6 байгууллагад хүргүүлэн, тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн.

-Дээрх аяны хүрээнд 2022.05.22-2022.05.16 ны өдрийг хүртэлх хугацаанд сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын албан хаагчдын дунд “ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛОН” – ыг 3 шалгуураар (Мэндлэх, хүндлэх, албан тушаалаар нь дуудах, хувцаслалт, Удирдлагын өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ажлын цаг ашиглалт) 31 албан тушаалтанд нээж, зөрчил гаргасан тохиолдол бүрт талоныг цоолох арга хэмжээг авч, 2022.06.16 ны өдөр шалгуурыг дүгнэхээр ажиллаж байна.

-“ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ-АЛХАНГАА ЯРИЛЦЬЯ” аяныг 2022.05.03 наас 2022.05.30 ны хооронд зохион байгуулахаар удирдамжаа гарган ажиллаж, энэ талаар төсвийн байгууллагуудад албан бичгээр үүрэг чиглэл өгөөд байна.

Уг ажлын хүрээнд 2022.05.21 ний өдөр сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-ын ажилтан албан хаагчид бусад байгууллагуудаа манлайлан “ЯВГАН АЯЛАЛ” зохион байгуулж, аялах хугацаандаа 4 дүгээр багийн нутаг “УСТ БҮРД”-ний орчныг цэвэрлэж, мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэл хийж, хамт олны эерэг хандлагыг бий болгох зорилгоор буухиа тэмцээн зохион байгууллаа.

-Автотехникийн улсын үзлэгт 310 тээврийн хэрэгсэл хамрагдаж тээврийн хэрэгслийн татварт 15 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 9520000 төгрөгийг төсөвт төвлөрүүллээ.

-Агаар бохирдуулагийн татварт 1 сая төгрөг төвлөрүүлэхээс 800500 төгрөг төсөвт төвлөрүүлээд байна.

-Татвар төлөгчдийн өдөрт зориулж ЕБС-ийн сурагчдын дунд “Миний мэддэг татвар” сэдэвт гар зургийн уралдаан, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж дүгнэлээ.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

-Сумын Засаг даргын 2022 оны А/44 дүгээр захирамжаар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарих ажлаар 4 группэд 11 хүн ажиллаж 238366 үхэрт 40 гахайнд вакцин тарьсан нь 100% ийн гүйцэтгэлтэй.

-Сэг зэмийн устгал хийгдсэн 2500 м/кв талбайд халдваргүйтгэл хийсэн.

-Усалгаатай ногооны талбайд төмс, хүнсний ногоо тариалах бүлгийн 8 гишүүнд нийтдээ 420 кг төмсний үрийг захиалгаар авчирч нийлүүлээд байна.

-Хүлэмжийн тариалалт хийх 8 иргэнд 8 хүлэмж шинээр олгоод байна.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Үндэсний бичиг, соёлын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдлэгч" уралдаант тэмцээнийг 5 сарын 06-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд нийт 6 баг оролцсоноос эхний 3 байрыг шалгаруулж урамшуулсан.

"Хичээнгүй сайхан бичигтэн"- "Зөв хурдан уншигч"- тус тус шалгаруулсан.

Мөн энэ үеэр дүрслэх урлагийн багш Б.Энхмаа, МХБУЗ-ын багш Б.Дашпүрэв нарын хамтарсан МУ-ын гавьяат багш Чулуунбор гуайн **"Дарьгангын 9 гайхамшиг"** шүлгээр бүтээсэн үзэсгэлэн дэлгэгдлээ.

2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Үндэсний бичиг соёлын өдрийн хүрээнд МУ-ын Соёлын элч, "Титэм Арт"-академийн тэргүүн Э.Ариунболд сургалт зохион байгуулж, "Эзэнт Гүрний Их хаадын захидал" үзэсгэлэнг танилцууллаа.

"САЙН БАГШИЙН - САЙН ТЕХНОЛОГИ" ур чадварын уралдааны II шатанд 3 багш амжилттай оролцлоо.

Эрүүл мэндийн сайдын, БСШУС-ын 2019 оны 11-р сарын 15-ны өдрийн А\514, А\736-р хамтарсан тушаалаар “Хүүхдийн биеийн жин, өндрийг бүртгэх, тандах, журам”-ын дагуу цэцэрлэгийн насны 115 хүүхдээс судалгаа авч эцэг эхчүүдэд зөвлөгөө өгч ажиллалаа.

Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд “**Миний гэр аюулгүй орчин**” сэдэвт судалгааг 120 эцэг эхээс авч, судалгааны асуумжийн дагуу айлууд өөрийн орон гэртээ үзлэг хийж, эрсдлийг засч сайжруулан ажилласан. Судалгаанд хамрагдаж чадаагүй хөдөөгийн 30 өрхөөс бүлгийн багш нар гэрийн эргэлт хийхдээ судалгааг авч бүлэг тус бүрээр нэгтгэж эцэг эхчүүдэд зөвлөгөөг өгч ажилласан.

Дөрөв. Эрүүл мэндийн чиглэлээр

-“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ- ЭРТЭЧ ДАРЬГАНГАЧУУД” аяны ҮР ДҮНГЭЭ үнэлж дүгнэх ажлыг 2022.05.20 ны өдөр зохион байгуулж, аянд хамгийн идэвхтэй оролцож, зохих үр дүнд хүрч, илүүдэл жин буурсан 7 хүнийг (үүнд иргэн 1, Ахмад-1, Аж ахуйн нэгжээс 1, төрийн албан хаагч 4) шагнаж урамшууллаа.

Сумын ЭМТ-д Монгол улс орон даяар зохиогдож байгаа “Урьдчилан сэргийлэх- эрт илрүүлэг үзлэг”-ийн нээлтийн арга хэмжээний хүрээнд ард иргэдэд танхимаар сургалт зохион байгуулж, үзлэгийн өрөө бэлтгэн 9 хүүхдийг үзлэгт хамрагдууллаа. Сургалт зөвлөгөөнд нийт 23 хүн хамрагдсан.

Геронтологийн үндэсний төвөөс зүрх судас, мэдрэл, арьс харшил, эхо, дотрын эмч зэрэг баг бүрэлдэхүүнийг сумын Ахмадын хорооноос урьж ирүүлэн, ахмадын урьдчилан сэргийлэх үзлэг хийгдэж нийт давхардсан тоогоор 551 ахмад хамрагдсан. Үүнээс: - дотор-138 , Мэдрэл 95, Зүрх судас 124, ЭХО 138, Арьс харшил 56, Дотор 138 .

Цэцэрлэгийн насны 73 хүүхдүүдийг эрт илрүүлэгт хамруулж А аминдэмээр витаминжууллаа.

ЕБС-ийн 6-17 насны 5 бүлгийн 120 хүүхдийг үзлэгт хамрагдуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Тав. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Хөдөлмөр халамийн үйлчилгээний хүрээнд “Малжуулах хөтөлбөр”-т 6 иргэний төсөл, Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 9 төсөл нийт 15 төслийг аймгийн ХХҮГ-т хүргүүлээд байгаа.

Төсөлд хамрагдах 4 иргэнд А В D гэсэн үнэлгээ өгч, D үнэлгээ авсан тохиолдолд төсөл олгохгүй байх зарчим мөрдөж байгаа.

Зургаа: Байгаль орчны чиглэлээр.

- Бүх нийтээр мод тарих өдрийг 2022.05.07-ны өдөр зохион байгуулсан. Аймгийн БАОЖГ-аас хандивласан 2000 ш хайлаасны суулгацыг Алтан овооны хашаанд суулган усалгаанд нийт 122150 төгрөгний 35л түлш зарцуулаад байна. Айл өрхийн хашаанд тарих 1000ш гоёлын болон жимсний модыг УБ хотын “ПЮР

ИНЖЕНЕРИНГ СОЛЮШН” ХХК-нд захиалга өгсөн одоогоор ирээгүй байна.

- Сумын Засаг даргын захирамжаар 2022.05.11-12 ны өдрүүдэд сумын төвийн эргэн тойрон дахь нуур ус, булаг шанданд үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг ачиж тээвэрлэх ажлыг ЗДТГ-ын 9 албан хаагч халдвар хамгаалалын хувцасаар хангагдаж хийж гүйцэтгэсэн Нийт 34 бод, 10 богийн сэгийг устгалын цэгт хаясан. Цэвэрлэгээний явцад мал эмнэлэгийн тархвар зүйч ариутгал халдваргүйтгэлийг хийж ажилласан. Сэг зэм цэвэрлэгээний ажилд түлш бээлий маск хоолны зардалд нийт 500,000 төгрөг зарцуулсан.

- Сумын засаг даргын захирамжаар нийтийн эдэлбэр газарт бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулсан. Нийт 6 байгууллагын 150 гаруй албан хаагч 4 ангийн 80 гаруй сурагч оролцсон. 50 литр түлш, 40 литр А/92, 100ш бээлий 150ш маскаар хангаж 600,000 төгрөгний зардал гарсан.

- “**Байгальд ээлтэй шилдэг анги**” уралдааны хүрээнд ЕБС-ын ангиуд Байгаль орчны талаарх сургалт хэлэлцүүлэгийг хийж өөрсдийн санаачилгаараа нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээ болон мод тарих услах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА Д. БОЛДБААТАР